




“НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн
удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Н.Баасанхүү /"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн
дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	5



1. ХБҮЦ-ны мэдээлэл

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Нөмөр Кредит ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Н.Баасанхүү, хараат бус гишүүдээр Б.Рэнцэнханд, Б.Эрдэнэжаргал нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр 10.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны өрөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011839181
Регистрийн дугаар	6862705
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/09/21
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	452
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	50,000
ХБҮЦ (ширхэг)	100,000
ХБҮЦ-ны үлдэгдэл (сая төг.)	5,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	17.5%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2023 онд ХБҮЦ-ны үндсэн төлбөрт 5.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1.75 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2024/01/18	-	220,547,945.21	5,000,000,000.00
2	2024/04/18	-	218,150,684.93	5,000,000,000.00
3	2024/07/18	-	218,150,684.93	5,000,000,000.00
4	2024/10/18	5,000,000,000.00	220,547,945.21	-
Нийт		5,000,000,000.00	877,397,260.27	

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

2023 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 2022 оны эцсийн үлдэгдлээс 45.40 хувиар буурсан бөгөөд энэ нь ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн 50 хувь буюу 5.0 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр төлсөнтэй холбоотой юм.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын өрөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.12.31	2023.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	9,275,253,827.00	5,064,258,585.00	-45.40%
Зээлийн дундаж үлдэгдэл	17,144,646.63	14,938,815.88	-12.87%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	2.90%	1.35%	-1.55%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	12.45%	10.18%	-2.27%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	32.66%	33.87%	1.21%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	61.08%	54.45%	-6.63%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	11.02	16.46	49.33%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	29.18	22.99	-21.20%
Сарын дундаж төлбөрийн дүн	1,067,266.09	1,047,786.45	-1.83%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	1,886,108.58	1,847,926.17	-2.02%
Зээлийн тоо	541	339	-37.34%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	-
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	16,830,720,000	11,181,905,800.00	-33.56%
Чанаргүй зээлийн хувь	0.24%	0.00%	-0.24%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	1,920,714,343.77	11,847,659,765.83*	
Зээлийн үндсэн төлбөр	1,274,209,467.00	8,586,558,372.00	
Хүүгийн төлбөр	644,722,811.77	3,253,948,699.83	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	1,782,065.00	7,152,694.00	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2023 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 594.46 сая төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2023 оны эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 0.0 төгрөг, харилцах дансны үлдэгдэл 9.3 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	311	-
2	Буцаан шилжүүлсэн	119	1,652,067,798.00
3	Багцад нэмж бүртгэсэн	228	4,980,857,645.00
Нийт		658	6,632,925,443.00

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийг “Нөмөр Кредит ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Нөмөр Кредит ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч”) байна.

2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05/04 тоот шийдвэрээр Н.Баасанхүү, Б.Эрдэнэжаргал, Б.Рэнцэнханд нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар Н.Баасанхүүг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 4 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.01.10	Санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталгаажуулах тухай	2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
2	2023.04.06	Жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэж санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хангалттай гэж дүгнэв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарлан хуралдуулав.
3	2023.07.19	Тайлан баталгаажуулах тухай	2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
4	2023.10.09	Тайлан баталгаажуулах тухай	2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.